

**БАНКНЫ НЭГЖ БАЙГУУЛАХАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ
ТОГТООХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү нөхцөл, шаардлагын зорилго нь Банкны тухай хуулийн 18 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банканд Монгол Улсад болон гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, банкны нэгж байгуулах, түүнийг бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Банкны нэгж нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн үйл ажиллагааг эрхэлнэ.

1.3.Монголбанк банкны нэгжийн бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, бүтэц, хүний нөөц, ажлын байр зэргийг харгалзан тусгайлан шаардлага тавьж, эрхлэх үйл ажиллагааг хязгаарлаж болно.

1.4.Банк нэгж шинээр байгуулах, банкны нэгжийн хаяг, байршлыг өөрчлөх тухай бүр тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш энэхүү журмын нөхцөл, шаардлагыг хангасан байдлаар ажлын 5 хоногийн дотор Монголбанканд мэдээлнэ.

1.5.Банкны салбар байгуулахад энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж, 3 дугаар зүйлд заасан баримт бичгийг ирүүлсэнд үндэслэн Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу Монголбанк зөвшөөрөл олгоно.

1.6.Монголбанк банкны салбар байгуулах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаагаар олгоно.

1.7.Монголбанкны хяналт шалгалтаар банк нь банкны тухай хууль тогтоомж зөрчсөн болон энэ журамд заасан шаардлагыг хангахгүй болсон нь тогтоогдвол зөвшөөрлийг түдгэлзүүлж болно.

1.8.Монголбанк нь харилцагчдын эрх ашигт харшилсан, тухайн банкны хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулж болзошгүй нөхцөл үүссэн буюу банкны тухай хууль тогтоомж болон энэ журамд заасан шаардлагыг хангахгүй болсон нь Монголбанкны хяналт шалгалтаар тогтоогдвол банкны нэгж байгуулсан шийдвэрийг хүчингүй болгож болно.

**ХОЁР.БАНКНЫ НЭГЖ БАЙГУУЛАХ
НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

2.1.Монгол Улсад банкны нэгж байгуулахад дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1.Банкны тухай хуулийн 16, 17 дугаар зүйл болон Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 6 сарын турш тогтмол хангаж ажилласан;

2.1.2.Монголбанкнаас хамгийн сүүлд хийгдсэн газар дээрх иж бүрэн шалгалтын үнэлгээ нь “Хэвийн” ба түүнээс дээш байх;

2.1.3.банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх тухай Монголбанкнаас баталсан журмын дагуу хамгийн сүүлд авсан зохистой засаглалын үнэлгээ нь “Дунд” ба түүнээс дээш байх.

2.2.Дотоодын банк гадаад улсад банкны нэгж байгуулахад дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.банкны үйл ажиллагааг сүүлийн 2-оос доошгүй жилийн хугацаанд тогтвортой эрхэлсэн;

2.2.2.Банкны тухай хуулийн 16, 17 дугаар зүйл болон Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 12 сарын турш тогтмол хангаж ажилласан;

2.2.3.Монголбанкнаас хамгийн сүүлд хийгдсэн газар дээрх иж бүрэн шалгалтын үнэлгээ нь “Хэвийн” ба түүнээс дээш байх;

2.2.4.банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх тухай Монголбанкнаас баталсан журмын дагуу хамгийн сүүлд авсан зохистой засаглалын үнэлгээ нь “Дунд” ба түүнээс дээш байх;

2.2.5.тухайн банкны нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэх этгээд нь үүсгэн байгуулагдах улсын шалгуур, шаардлагыг хангасан байх;

2.2.6.тухайн банкны нэгжид хяналт шалгалт хийх, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлэх боломжтой байх;

2.2.7.банк, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх.

ГУРАВ. БАНКНЫ САЛБАР БАЙГУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

3.1.Банк салбар байгуулахад дараах баримт бичгийг Монголбанканд ирүүлнэ:

3.1.1.банкны салбарын эрхлэх үйл ажиллагааг тодорхой заасан, банкны салбар байгуулах хүсэлт бүхий албан бичиг;

3.1.2.банкны салбар байгуулах тухай банкны дүрэмд заасан эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр;

3.1.3.үүсгэн байгуулагдах улсын шалгуур, шаардлагыг хангасан банкны салбарын удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилсон тухай банкны дүрэмд заасан эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр;

3.1.4.банкны салбарын удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийн энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт;

3.1.5.банкны салбар байгуулах эдийн засгийн үндэслэл, бизнес төлөвлөгөө.

3.1.6.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн нэмэлт баримт, материал.

ДӨРӨВ.ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА

4.1.Банк нь банкны нэгжийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний тайланг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 05-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хувилбараар Монголбанканд ирүүлнэ.

4.2.Банкны нэгжийн мэдээллийг банкны гэрчилгээний хавсралтад тэмдэглүүлж баталгаажуулна.

4.3.Монголбанк шаардлагатай тохиолдолд банкны нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж болно.

4.4.Монголбанк энэ журмын биелэлтэд хяналт тавьж, Банкны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Банкны нэгж байгуулахад тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох,
хэрэгжүүлэх журмын нэгдүгээр хавсралт

..... **БАНКНЫ**

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ТОМИЛОГДОХ АЛБАН ТУШААЛ				
<i>(томилогдох албан тушаалын нэрийг энд бичнэ үү)</i>				
I. Товч танилцуулга				
Ургийн овог:		цээж зураг		
Овог:				
Нэр:				
Төрсөн огноо:				
Регистрийн дугаар:				
Иргэншил:				
Оршин суугаа хаяг:				
Цахим шуудангийн хаяг:				
Утасны дугаар:				
II. Боловсрол <i>(боловсролын гэрчилгээний хуулбарыг хавсаргана уу)</i>				
Боловсрол	Эзэмшсэн боловсрол/ хамгаалсан цол	Суралцсан хугацаа	Сургуулийн нэр	Улс, хотын нэр
...				
...				
III. Ажил эрхлэлт				
Одоо ажиллаж байгаа байгууллага				
Албан тушаалын нэр				
Албан тушаалд томилогдсон огноо				
Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, утасны дугаар				
Өмнөх хугацаанд ажилласан байгууллага	Албан тушаалын нэр	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон огноо	Ажлаас гарсан огноо, шалтгаан
...				
...				
Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.				

д/д	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар	
1				
2				
...				
Хуулийн этгээд, банкны хувьцаа эзэмшдэг бол доорх хүснэгтийг бөглөнө үү.				
	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар	
1				
...				
IV. Гэр бүлийн байдал (гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээллийг оруулна уу)				
	Овог, нэр, дугаар	Регистрийн	Таны юу болох	Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал
1				
...				

Иргэний үнэмлэх/паспортын хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан.

(нэр)

(гарын үсэг)

..... оны сарын-ний өдөр

Банкны нэгж байгуулахад тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох,
хэрэгжүүлэх журмын хоёрдугаар хавсралт

..... **БАНКНЫ НЭГЖИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЙЛАН**

20...оны...дугаар сарын...өдөр

д/д	Салбарын тоо			Салбараас бусад нэгжийн тоо			Төлөөлөгчийн газар	Банкны нэгжийн тоо /өмнөх улирал/	Банкны нэгжийн тоо /тайлант улирал/	ӨӨРЧЛӨЛТ					
										Шинээр нээсэн			Байршил өөрчлөгдсөн		
	УБ хот	Орон нутаг	Гадаад улс	УБ хот	Орон нутаг	Гадаад улс	Гадаад улс	а) банкны шийдвэр огноо	б) тоо	в) байгуулсан огноо	а) банкны шийдвэр огноо	б) тоо	в) өөрчилсөн огноо		
1															
2															
3															
Нийт															

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

/нэр/

Салбар нэгжийн Удирдлагын газрын захирал:

/нэр/

Салбар нэгжийн Удирдлагын газрын ажилтан:

/нэр/